

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 268

Улаанбаатар хот

Г Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн 7
технологийн бодлогын баримт бичиг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг
үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Мэдээллийн технологийн бодлогын баримт
бичиг”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Мэдээллийн технологийн бодлогын баримт бичиг”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж
ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.

1.1. Энэхүү баримт бичгээр Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны ажлын дотоод зохион байгуулалтын болон зохицуулалтын үйл ажиллагааны хүрээний мэдээллийн технологи /цаашид “МТ” гэх/-ийн үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлно.

1.2. Мэдээллийн технологийн нэгж /цаашид “МТН” гэх/-ийн хэрэгжүүлэх чиг үүргийг хамрах хүрээ, чиглэл тус бүрээр дараах байдлаар төрөлжүүлж бүлэглэнэ. Үүнд:

1.2.1. МТ-ийн бодлого, хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

а/ Санхүүгийн салбарын мэдээлэл, технологийн чиглэл, хэтийн төлөвлөгөө, зөвлөмж, стандарт, холбогдох журмуудыг боловсруулах, хэрэгжүүлэх;

б/ Дотоодын болон гадаадын байгууллагаас Хорооны дэргэд хэрэгжих мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан хяналт тавьж ажиллах;

1.2.2. Хорооны МТ-ийн дотоод зохион байгуулалт

а/ Хороо, Ажлын албанд ашиглагдаж буй дотоод мэдээллийн сүлжээний найдвартай ажиллагаа, мэдээллийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт, нууцлалыг хариуцах;

б/ Хорооны хэрэгцээнд програм хангамж боловсруулах, шинэ технологи судлах, нэвтрүүлэх;

в/ Хорооны газар, хэлтсүүдийн санхүүгийн мэдээлэл, нэгтгэл хариуцсан ажилтнуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, нийт ажилтнуудад мэдээлэл, технологийн чиглэлийн сургалтыг төлөвлөгөөтэй зохион байгуулах;

г/ Хорооны компьютерийн холбогдох техник хангамжийн захиалга, суурилуулалт, туршилт, тэдгээрийн найдвартай ажиллагаа, засвар үйлчилгээг хариуцан ажиллах;

1.2.3. Хорооны үйлчилгээний хамрах хүрээ, мэдээллийн сан

а/ Хорооны зохицуулалтын үйлчилгээний хамрах хүрээнд мэдээллийн нэгдсэн сан, сүлжээ байгуулах, түүний нууцлал аюулгүй байдлыг хангах, програм хангамжийн хэвийн ажиллагааг хангах, хөгжүүлэх сайжруулах;

б/ Хорооны Вэб хуудасны хэвийн, найдвартай ажиллагааг хангаж ажиллах, цаашид хөгжүүлж, сайжруулах, Хорооны Ажлын албанаас ирүүлсэн баримтын дагуу Вэб хуудсанд нэмэлт мэдээлэл байршуулах эсхүл хасах ажлыг тухай бүр шуурхай гүйцэтгэх;

в/ Санхүүгийн салбарын хэрэглэгч, оролцогчдын хууль ёсны эрх ашгийг, болзошгүй эрсдэлээс хамгаалах, Хорооны хүлээх чиг үүргийн дагуу санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглах програм хангамжид хяналт тавьж, үзлэг хийх, мэргэжлийн дүгнэлт, тайлан, акт гаргах, зөвлөгөө өгөх.

ХОЁР. МТ-ИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1. Мэдээллийн технологи нь маш хурдацтай хөгжиж байдаг тул МТН нь дээр дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Олон Улсад баримтлах зарчим, стандартыг мөрдөх боломжийг судалж Хорооны удирдлагад тухай бүр танилцуулж байна. Стандартыг зайлшгүй нэвтрүүлэх шаардлагатай болсон тохиолдолд төсөв, санхүүжилтийг Хороо болон Ажлын алба шийдвэрлэж өгнө.

2.2. Хорооны мэдээлэл болон мэдлэгийн сан нь стратегийн ач холбогдолтой тул Хороо болон Ажлын албанаас МТН-ийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, улмаар мэдээллийн технологийн хөгжлөөс хоцорч Хороонд МТ-ийн хувьд эрсдэлд орохгүй байх нөхцлийг хангана.

2.3. Хорооны МТ-ийн бодлого, МТН-ийн хариуцан ажиллах чиг үүргийн дагуу МТ-ийн бодлого, хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, Хорооны үйлчилгээний хамрах хүрээ, мэдээллийн сан зэрэгтэй холбогдуулан баталж мөрдөх, мөрдүүлэх, үйл ажиллагаандаа хэрэглэхэд шаардлагатай журам, тогтоол, тушаал, удирдамж болон бусад баримт бичгийг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх эсвэл Хорооны даргын тушаалаар батлуулна. Харин Хорооны МТ-ийн дотоод зохион байгуулалтын хүрээнд баталж мөрдөх, мөрдүүлэх журам, стандарт, заавар, гарын авлага болон бусад баримтыг Ажлын албаны даргын тушаалаар, эсвэл МТН-ээс батална.

2.4. Үйл ажиллагаанд мөрдөх дээрх баримт бичгийг тухай бүр шинэчилж, технологийн хөгжлийн төвшинд нийцүүлэх сайжруулах ажлыг МТН хариуцан ажиллана.

2.5. МТН-ийн ажилтан Хорооны мэдээллийн агуулгыг бие даан боловсруулах, өөрчлөлт оруулахыг хориглоно. МТН нь гагцхүү мэдлэгийн удирдлага, мэдээллийн удирдлага, зохион байгуулалт, хадгалалт, нууцлалыг хариуцан ажиллана.

2.6. Хороо болон түүний зохицуулалтын хүрээний байгууллагуудад МТ-ийн аудитыг тухайн үйлчилгээ хийх эрх бүхий байгууллагаар тодорхой хугацаанд тогтмол хийлгэх бөгөөд зохих удирдамжийн дагуу ажлыг МТН Хорооны Ажлын албаны зохих нэгжтэй хамтарч гүйцэтгэнэ. Хорооны үйлчилгээний хамрах хүрээний байгууллагад хийсэн МТ-ийн аудитаар тухайн байгууллагын өөрийн, харилцагчийн болон хөрөнгө оруулагчийн эрх ашиг хөндөгдөх эрсдэл байна гэсэн дүгнэлт гарсан бол үүнд үндэслэн МТН-ийн ажилтан акт үйлдэж, хуулбарыг Хорооны Ажлын албаны үндсэн чиг үүргийн харгалзах газарт хүргүүлнэ.

2.7. Орчин цагт МТ-ийн хүрээ мэдээллийнхээс гадна харилцаа холбооны технологийг хамарч ойлгодог. Хороо хуулийн дагуу үзүүлэх үйлчилгээ үйл ажиллагааныхаа онцлогийн хүрээнд гуравдагч этгээд болон харилцагч талтай харилцаа холбоо тогтоох шаардлага гарна. Гуравдагч этгээд, харилцагчтай холбогдож мэдээлэл солилцох 3 төвшин байна. Үүнд:

а/ Хороо бусад төрийн байгууллага болон бусад төрийн бус, мэргэжлийн байгууллага хоорондын. Тогтсон тусгаар мэдээллийн төвөөр дамжсан эсвэл бие даасан холболт байгуулж болно, зөвшөөрөгдөх нөхцөлд Хорооны цахим хуудсаар холбогдож болно;

б/ Хороо зохицуулах хүрээний этгээд хоорондын. Хорооны цахим хуудас, цахим шуудангаар дамжих;

в/ Хороо олон нийттэй харилцах. Хорооны цахим хуудсаар дамжина.

Эдгээр холболтыг байгуулах, холбогдох төхөөрөмж, програм хангамжийг суурилуулах, мэдээлэл солилцох систем бүрдүүлэх, цахим мэдээлэл солилцооны стандарт тогтоох, холбогдох бусад ажлыг зохион байгуулахад гуравдагч этгээд эсвэл харилцагч талтай хамтарч ажиллана, шаардагдсан тохиолдолд хамтарсан ажлын хэсэг байгуулна.

2.8. Хорооны зохицуулалтын хүрээнд хамрах санхүүгийн зах зээл дэх үйлчилгээнд МТ голлох үүрэг гүйцэтгэх тохиолдолд, Хорооноос холбогдох дүрэм, журам баталж гаргахдаа МТН-ээс санал, дүгнэлтийг гаргуулна.

2.9. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Хороо өөрийн бүрдүүлсэн мэдээллийн санг Нууцын тухай хууль, бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй байдлаар гадаадын судалгааны институт, мэдээллийн агентлагуудад гэрээ байгуулан хүргүүлж, орлого олж болно.

2.10. Хорооны цахим мэдээлэл, мэдээллийн сан, програм хангамжийн болон бусад төхөөрөмжийн тохиргоо нөөцлөх сэргээлтийн (BACKUP) болон толин (MIRROR) системтэй байна. Гамшгийн тохиолдлын мэдээлэл сэргээлтийн зохицуулалттай (DISASTER RECOVERY) байна.

2.11. МТН нь хариуцан Програм хангамж боловсруулах тохиолдолд програмын хэвийн ажиллагаа хангагдсан, гадаад болон дотоод халдлагаас хамгаалагдсан байхаар, төхөөрөмжийн хүчин чадалд нийцүүлэн гүйцэтгэнэ. Хорооны Ажлын албанаас МТН-ид шаардагдах нөхцлийг бүрдүүлэх бөгөөд програмыг хэрэглэх газар, хэлтэс хамтарч ажиллана. Програмыг бичиж ашиглалтад оруулахад төхөөрөмжийн хүчин чадлыг өргөтгөх шаардлагатай бол Хорооны удирдлагад танилцуулж шийдвэрлүүлнэ.